



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: СЭА-2023/44-1-ШТА-ГА

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД НЬ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭЛГҮЙГЭЭР
ТҮЛШ, ХАЛААЛТЫН ТӨЛБӨРИЙГ НЭХЭМЖИЛСЭН ДҮНГЭЭР БАРАГДУУЛЖ
БАЙГАА НЬ ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

Сүхбаатар сум 2023 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com

Аудитор О.Анхбаяр

Утас: 70362442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Аудитор Б.Наранцэцэг

Утас: 70363047 Цахим хаяг: narantsetsegba@audit.gov.mn

Аудитор Т.Мөнхзул

Утас: 70363047 Цахим хаяг: munkhzult@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Дүрслэлийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл	6
<i>Бүлэг 1: Дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээг дүгнэхгүй байгаа нь дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагаа жигд явагдахгүй байх эрсдэлийг дагуулж байна.</i>	7
1.1 Тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа явуулж байгаа нь төсвийн байгууллагуудыг стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.	7
1.2 Төсвийн байгууллагууд нь дулаанаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүйгээс түлш, халаалтын зардлыг хэмнэх боломжийг алдсан байна.	11
<i>Бүлэг 2: Төсвийн байгууллагууд гэрээний хэрэгжилтийг дүгнэлгүйгээр халаалт дулааны төлбөрийг бүрэн төлсөн нь төсвийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.</i>	14
2.1 Төсвийн байгууллагууд нь шинэчилсэн тарифыг мөрдөж түлш, халаалтын зардлыг төлөвлөөгүйгээс батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.	14
2.2 Аймгийн ЭХЗЗ төсвийн жилийн дундуур дулааны тарифыг шинэчлэн, мөрдөх шийдвэр гаргасан нь төсвийн байгууллагуудад түлш, халаалтын өр төлбөр үүсэх эрсдэлийг дагуулж байна.	16
Аудитаар илэрсэн зөрчил	19
Дүгнэлт	19
Зөвлөмж	20
Ирүүлсэн санал, тайлбар	21

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо

Хүснэгтийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ЭХЗЗ-өөс 2021, 2022 онд тусгай зөвшөөрөл шинээр олгосон, хугацааг сунгасан байдал	7
Хүснэгт 2	Дулаанаар хангагч байгууллагуудын мөрдөж байгаа тариф	8
Хүснэгт 3	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхцөл, шаардлагын биелэлтийг үнэлсэн байдал	11
Хүснэгт 4	Төсвийн байгууллагуудын түлш, халаалтын зардлын төсвийн төсөл	14
Хүснэгт 5	Тогтоосон тарифаас зөрүүтэй тооцсон байдал	14
Хүснэгт 6	Түлш, халаалтын зардлын төсвийн төсөл болон тухайн оны батлагдсан төсвийн зөрүү	15
Хүснэгт 7	Төсвийн байгууллагуудын түлш халаалтын зардлын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлт	16
Хүснэгт 8	Дулаанаар хангагч байгууллагуудын түлш халаалтын авлага, өр төлбөр	17
Хүснэгт 9	Харьцуулалтын аргын босго үнээс давсан нүүрс, түлээний модны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байгууллагууд	18

Дүрслэлийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1-2	Дулаанаар хангагч байгууллагуудын халаалтын үйл ажиллагааг хэрэглэгчдийн зүгээс үнэлсэн байдал	13
Дүрслэл 3	Орон нутгийн төсвийн байгууллагуудын түлш, халаалтын зардлын төлөвлөлт	15

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 06 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/02 дугаар тушаал, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Төсвийн байгууллагуудын 2021, 2022 оны халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, дулааны эрчим хүчээр хангагч аж ахуйн нэгжүүдэд хууль, тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч байна уу?
- Төсвийн байгууллагууд түлш халаалтын зардлыг бодитоор төлөвлөж, үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ЭХЗЗ, дулаан үйлдвэрлэх, дулааны эрчим хүчээр хангагч 21 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл олгох, эзэмших үйл ажиллагаа, төвлөрсөн халаалттай 169, өөрийн галлагаатай 21, цахилгаанаар халаадаг 3 зэрэг нийт 193 төсвийн байгууллагын 2021, 2022 оны түлш халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, өөрийн галлагаатай байгууллагуудын нүүрс, түлээний худалдан авалттай холбоотой баримт материалуудыг хамруулав.

Мөн аймгийн ТЕЗ, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн алба, төсвийн байгууллагуудын дарга, нягтлан бодогч, бусад ажилтнуудаас асуулга, тодруулга мэдээлэл авч, түлш халаалтын зардалтай холбоотой гаргасан шийдвэр, дулааны эрчим хүч хэрэглэгч талуудын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх байдлаар аудитад хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2021 оны А/81 дүгээр тушаал, А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.

Аудитаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд шинжилгээ хийх, шалгадагч болон хамрагдагч байгууллага, албан тушаалтнуудаас асуулга, лавлагаа, тайлбар авах, харьцуулах, нэгтгэх, нөхцөл байдлын болон дүн шинжилгээ хийх зэргээр нотлох зүйлс цуглуулж, үр дүнг нягтлан шалгаж, аудитын дүн, дүгнэлтийг боловсруулав.

Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд: • Төсвийн тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Аж ахуйн харилцааны дүрэм”, • ЭХЗХ-ны 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”, • ЭХЗХ-ны 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Тариф батлах тухай” 457 дугаар тогтоол, түүний хавсралт, • ЭХЗХ-ны 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн “Тариф батлах тухай” 458 дугаар тогтоол, түүний хавсралт, • ЭХЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Тариф батлах тухай” 469 дүгээр тогтоол, түүний хавсралт, • ЭХЗХ-ны 2021 оны 499 дүгээр тогтоолоор баталсан “Аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дүрэм”, • Аймгийн ЭХЗХ-ийн 2015 оны “Тарифт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 45 дугаар тогтоол, • Аймгийн ЭХЗХ-ийн 2016 оны “Үнэ, тарифт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 07-26 дугаар тогтоол, • Аймгийн ЭХЗХ-ийн 2017 оны “Үнэ, тариф батлах тухай” 11 дүгээр тогтоол, • Аймгийн ЭХЗХ-ийн 2022 оны “Тарифт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 05-20 дугаар тогтоол, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 16 дугаар тогтоол, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 55 дугаар тогтоол болон бусад холбогдох эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор О.Анхбаяр, Б.Наранцэцэг, Т.Мөнхзул нар 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

**Ерөнхий
мэдээлэл:**

Дулаанаар хангагч 21 (ЭХЗХ-оос олгосон 2, аймгийн ЭХЗЗ-өөс олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч 17, тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа 2) аж ахуйн нэгжүүд нь тухайн сум, орон нутгийн төвлөрсөн халаалттай төсвийн 169 байгууллагатай дулаанаар хангах, дулаан хэрэглэх гэрээ байгуулж ажилласан байна. Төсвийн 193 (Төвлөрсөн халаалттай 169, өөрийн галлагаатай 21, цахилгаанаар халаадаг 3) байгууллага нь түлш, халаалтын зардалд 2021 онд 10,379.5 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 9,947.0 сая төгрөгийг, 2022 онд 13,579.9 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 12,852.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бүлэг 1

Дулаан үйлдвэрлэх, дулааны эрчим хүчээр хангагч аж ахуйн нэгжүүдэд хууль, тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч байна уу?

Дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээг дүгнэхгүй байгаа нь дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагаа жигд явагдахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

1.1 Дулаанаар хангах тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох болон сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэж байна уу?

Тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа явуулж байгаа нь төсвийн байгууллагуудыг стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

1.1.1 Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1-д “Энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох” гэж аймгийн зохицуулах зөвлөлийн эрх, үүргийг тодорхойлсон бол 12 дугаар зүйлийн 12.4-т “Энэ хуулийн 12.2, 12.3-т зааснаас бусад тусгай зөвшөөрлийг аймгийн зохицуулах зөвлөл олгоно.” гэж заасан байдаг.

1.1.2 Дээрх заалтын дагуу аймгийн ЭХЗЗ нь нийт 18 аж ахуйн нэгжид дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав.) олгосон бөгөөд аудитад хамрагдаж буй 2021-2022 онд 11 аж ахуйн нэгжид дараах байдлаар тусгай зөвшөөрөл олгож, хугацааг сунгасан байна Үүнд:

- 2021 онд дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах чиглэлээр нийт 6 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 1 тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан,
- 2022 онд 2 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2 тусгай зөвшөөрөл шинээр олгосон гэх мэт.

Аймгийн ЭХЗЗ-өөс 2021, 2022 онд тусгай зөвшөөрөл шинээр олгосон, хугацааг сунгасан байдал

Хүснэгт №1

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Дулаанаар хангах сум, тосгоны нэр	Тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан					Хүчинтэй хугацаа /жил/	Тайлбар
			Тогтоолын		Үйлдвэрлэх	Түгээх	Зохицуулалт -тай хангах		
			Огноо	Дугаар					
1	“Энержиплас Инженеринг” ХХК	Сант, Баруунбүрэн	2021.03.12	05	1	1	1	10	Сунгах
2	“Хэрх илч” ХХК	Мандал сумын Хэрх тосгон	2021.03.12	06	1	1	1	10	Сунгах

3	“Хүдэр дулаан” ХХК	Хүдэр	2021.03.12	07	1	1	1	10	Сунгах
4	“Гавшгай-Ус” ААТҮГ	Сайхан сумын Номгон тосгон	2021.03.12	08	1	1	1	10	Сунгах
5	“Спирт бал бурам” ХХК	Мандал	2021.12.24	09	1	1	1	10	Сунгах
6	“Зоригт-Алтай” ХХК	Түшиг	2021.12.24	10	1	1	1	10	Сунгах
7	“Эл Си Би” ХХК	Шаамар сумын МСҮТ, Цагааннуур, Орхон	2021.12.24	11	1	1	1	10	Нэмэлт өөрчлөлт оруулах
8	“Буга өндөр” ХХК	Алтанбулаг, Ерөө сумын Бугант тосгон	2022.11.01	05	1	1	1	10	Шинээр
9	“Болд төмөр ерөө” гол ХХК	Ерөө, Баянгол / өөрийн аж ахуйн нэгжийг дулаанаар хангах /	2022.11.01	06	1			10	Шинээр
10	“Түнхэл дулаан” ХХК	Мандал сумын Түнхэл тосгон	2022.11.01	07	1	1	1	10	Сунгах
11	“Анужээ” ХХК	Баянгол	2022.11.01	08	1	1	1	10	Сунгах

Эх сурвалж: Аймгийн ЭХЗЗ-ийн 2021, 2022 оны тогтоол

1.1.3 Аудитад хамрагдсан 2021-2022 онуудад аймгийн ЭХЗЗ-ийн дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгох, эзэмших үйл ажиллагаанд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Буга өндөр” ХХК нь “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”, “Болд төмөр ерөө гол” ХХК нь “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа, үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл” зэрэг баримт, материалуудыг дутуу ирүүлсэн байхад өргөдлийг буцаалгүйгээр тусгай зөвшөөрөл олгосон байна. Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2¹, 21.5² дахь заалт болон ЭХЗХ-ны 2019 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 3.1³ дэх заалтыг тус тус зөрчсөн байна.
- Тусгай зөвшөөрлийг сунгуулахаар ирүүлсэн “Түнхэл дулаан”, “Зоригт-Алтай” ХХК-иудын өргөдлийг хугацаа хоцроож шийдвэрлэсэн байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4⁴, “Спирт бал бурам”, “Зоригт-Алтай”, “Анужээ” ХХК-иуд нь тусгай зөвшөөрлийг сунгуулах өргөдлийг хугацаа хоцроож аймгийн ЭХЗЗ-д хүргүүлсэн нь 22 дугаар зүйлийн 22.3⁵ дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.
- Буга өндөр ХХК, Төгөлдөр Ерөө, Илдэн бүрэн ОНӨААТҮГ-ууд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүйгээр төсвийн байгууллагуудтай дулаанаар хангах гэрээ байгуулан, үйл ажиллагаа явуулж эхэлсэн атал Эрчим хүчний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1⁶-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд арга хэмжээ аваагүй байна.

¹ Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлдөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан хавсаргах бичиг баримтыг хавсаргана ...

² Хэрэв өргөдөл, түүнд хавсаргасан баримтыг шаардлага хангаагүй гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор өргөдлийг буцаана.

³ Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч хуулийн этгээд нь ... баримт бичиг болон шаардлагатай бусад материалыг бүрдүүлнэ.

⁴ Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргана.

⁵ Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

⁶ Эрчим хүчний тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрчим хүчний улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна: 37.1.1. тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн, ... бол олсон борлуулалтын орлогыг хурааж, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх

1.1.4 Ерөө, Зүүнбүрэн сумын төсвийн байгууллагуудыг дулааны эрчим хүчээр хангагч “Монжим трейд” ХХК-ийн үйл ажиллагаа муу, нөхцөл, шаардлагыг хангахгүй байна гэх үндэслэлээр сумын “Онцгой комисс”-ын тогтоолоор дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүй “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ, “Илдэн бүрэн” ААТҮГ-уудад шилжүүлсэн бөгөөд эдгээр орон нутгийн өмчит газрууд нь өнөөдрийг хүртэл тусгай зөвшөөрөл аваагүй байна.

1.1.5 Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3-т “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх” гэж аймгийн ЭХЗЗ-ийн эрх, үүргийг тодорхойлсон бол 27 дугаар зүйлийн 27.1-д “... аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь хангагчаас үзүүлж байгаа үйлчилгээний нөхцөл, үнийг жил бүр, тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдол бүрд хянана” гэж заасан байдаг.

1.1.6 Аймгийн ЭХЗЗ-өөс 2016 онд “Үнэ тарифт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор баталсан үнэ, тарифыг дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах байгууллагууд мөрдөж байсныг 2022 онд ЭХЗХ-ны 2014 оны 231 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-ын 1.2⁷-т заасны дагуу 20-30 хувиар нэмэгдүүлж, шинэчлэн тогтоосон байна.

1.1.7 Дулаанаар хангагч байгууллагууд нь аймгийн ЭХЗЗ-өөс тогтоосон дараах тарифыг мөрдөж байна.

Дулаанаар хангагч байгууллагуудын мөрдөж байгаа тариф

Хүснэгт №2

№	Сум, тосгоны нэр	Дулаан хангагч байгууллагын нэр	Мөрдөж байгаа тариф		
			Төг/м ³ /задгайгаар/	Тоолуураар	
				Төг/Гкал	Төг/Гдж
1	Алтанбулаг сум	“Буга өндөр” ХХК	1,772.70	-	24,953.70
2	Баруунбүрэн сум	“Энержиплас инженеринг” ХХК	1,421.94	-	-
3	Баянгол сум	“Анужээ” ХХК	1,268.17	-	-
4	Ерөө сум	“Монжим трейд” ХХК	1,400.00	77,500.00	18,540.00
5	Ерөө сумын Бугант тосгон	“Буга өндөр” ХХК	1,900.00	-	24,953.70
6	Жавхлант сум	“Монжим трейд” ХХК	1,384.24	76,500.00	18,301.00
7	Зүүнбүрэн сум	“Монжим трейд” ХХК	1,480.17	-	-
8	Мандал сум	“Спирт бал бурам” ХХК	1,321.24	74,800.00	17,895.00
9	Мандал сум	“Мандал Энержо” ОНӨААТҮГ	1,471.25	74,800.00	17,895.00
10	Мандал сум	УБТЗ.БАУ-ний 1-р анги	1,560.00	74,800.00	17,849.00
11	Мандал сум (нэгдсэн эмнэлэг)	“Ураншоргоолж” ХХК	1,477.32	74,800.00	17,895.00
12	Мандал сумын Хэрх тосгон	“Арвижих өргөө” ХХК	1,381.40	-	-
13	Мандал сумын Хэрх тосгон	“Хэрх илч” ХХК	1,381.40	-	-
14	Мандал сумын Түнхэл тосгон	“Түнхэл дулаан” ХХК	1,321.24	-	-

хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

⁷ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны сүүлийн 3 жилийн бодит зардлын гүйцэтгэлд тулгуурлан энэхүү аргачлалын дагуу тарифыг тооцож, саналыг ЭХЗХ-д оруулна.

15	Орхон сум	“Эл Си Би” ХХК	1,911.50	4,390.19	-
16	Орхонтуул сум	“Туулын хишиг” ОНӨААТҮГ	1,470.02	86,560.00	-
17	Сайхан сум Номгон тосгон	“Гавшгай-Ус” ААТҮГ	1,400.49	74,800.00	17,895.00
18	Сант сум	“Энержиплас инженеринг” ХХК	1,219.61	-	-
19	Түшиг сум	“Зоригт-Алтай” ХХК	1,177.99	-	-
20	Хушаат сум	“Монжим трейд” ХХК	1,481.60	80,500.00	19,258.00
21	Хүдэр сум	“Хүдэр дулаан” ХХК	1,481.97	-	-
22	Цагааннуур сум	“Эл Си Би” ХХК	1,560.00	4,390.19	-
23	Шаамар сум	Алтанбилэг ХХК	1,214.14	-	-
24	Шаамар сумын Дулаанхан тосгон	Алтанбилэг ХХК	1,317.31	-	-
25	Шаамар сумын МСҮТ	“Эл Си Би” ХХК	1,558.05	4,390.19	-

1.1.8 Аймгийн ЭХЗЗ нь 2022 онд Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан тариф тогтоох зарчмыг мөрдлөг болгож дулааны эрчим хүчний тарифыг тогтоосон гэх боловч тооцооллыг нэг бүрчлэн хийлгүйгээр 2016 онд тогтоосон үнийг 20-30 хувь нэмэгдүүлэн тооцсон байна.

1.1.9 Аймгийн ЭХЗЗ-өөс тогтоосон 1м³ дулааны тариф нь ЭХЗХ-ны тогтоосон тарифаас харьцангуй бага байхаас гадна газар зүйн нэг бүсэд байрладаг сумдад харилцан адилгүй байна. Тухайлбал:

- ЭХЗХ-оос 1м³ дулааны тарифыг Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-т 2,166.1 төгрөгөөр (2019 онд), Сайхан суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Хөтөл энерги дулаан” ХХК-д 2,166.0 төгрөгөөр (2021 онд) тогтоосон нь аймгийн ЭХЗЗ-өөс тогтоосон үнээс 254.6-946.49 төгрөгөөр их байна.
- 2022 онд аймгийн ЭХЗЗ-өөс 1 м³ дулааны тарифыг Орхон суманд 1,911.50 төгрөг, Сант суманд 1,219.61 төгрөг, Сайхан сумын Номгон тосгонд 1,400.49 төгрөгөөр тогтоосон гэх мэт.

1.1.10 Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8-д “Нэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч хуулийн этгээд өргөдөл гаргасан бол сонгон шалгаруулах замаар олгоно.”, Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Эрчим хүчний тухай хуулийн 21.8 дахь заалтын хүрээнд нэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хэд хэдэн сонирхогч хуулийн этгээд өргөдөл гаргасан тохиолдолд сонгон шалгаруулах замаар тусгай зөвшөөрлийг олгоно.” гэж заасан байдаг.

1.1.11 Аудитад хамрагдсан хугацаанд нэг суманд хэд хэдэн сонирхогч аж ахуйн нэгж дулаан үйлдвэрлэх, дулаанаар хангах үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг аймгийн ЭХЗЗ-д ирүүлээгүй тул тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт хийгдээгүй байна.

1.1.12 Харин Алтанбулаг, Цагааннуур, Шаамар сумд, Бугант тосгон нь худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргын босго үнээс давсан дулаанаар хангагч байгууллагуудыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан нь үйл ажиллагаа доголдох, хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлийг үүсгэж байна.

1.1.13 Аймгийн ЭХЗЗ-ийн дулаан үйлдвэрлэх, дулаанаар хангах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн ЭХЗЗ нь холбогдох хууль, тогтоомжийг сурталчлах, олон нийтэд мэдээлэх болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зөвлөмж, чиглэл өгч, мэргэжил арга зүйгээр хангах ажиллагаа хангалтгүй байгаагаас хууль тогтоомжийг мөрдөөгүй, эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах үйл ажиллагаа доголдох, хариуцлага тооцох механизм алдагдах эрсдэлийг дагуулж байна.
- Үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмын дагуу үдэж хавтаслаагүй, эмхэлж цэгцлээгүй бөгөөд батлагдсан үнэ тарифыг олон нийтэд мэдээлэх, нийтлэх ажил хийгдээгүй байна.

1.2 Дулаанаар хангагч байгууллагуудтай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, хяналт шалгалт хийж байна уу?

Төсвийн байгууллагууд нь дулаанаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүйгээс түлш, халаалтын зардлыг хэмнэх боломжийг алдсан байна.

1.2.1 Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн харилцааг Иргэний тухай хууль, энэ хууль, аж ахуйн харилцааны дүрэм, эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.” гэж заасны дагуу дулаанаар хангагч 21 (ЭХЗХ-оос олгосон 2, аймгийн ЭХЗЗ-өөс олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч 17, тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа 2) аж ахуйн нэгж нь тухайн сум, орон нутгийн төвлөрсөн халаалттай төсвийн 169 байгууллагатай “Дулаанаар хангах, дулаан хэрэглэх гэрээ”-ний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна.

1.2.2 Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга Эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.” гэсэн заалтын дагуу Орхон, Цагааннуур сумын Засаг дарга нар нь “Эл Си Би” ХХК-тай “Сумын төвийг нэгдсэн халаалтаар хангаж, хамтран ажиллах гэрээ”-г, Алтанбулаг сумын Засаг дарга нь “Буга өндөр” ХХК-тай “Алтанбулаг сумын төвийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг дулаанаар хангаж, хамтран ажиллах хөрөнгө оруулалтын гэрээ”-г тус тус байгуулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна.

1.2.3 Тайлант онуудад дулаанаар хангагч дээрх 21 аж ахуйн нэгж, байгууллага нь дулааны эрчим хүч хэрэглэгч буюу төсвийн байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан байна.

1.2.4 Дулаанаар хангах, дулаан хэрэглэх гэрээг 56 байгууллагатай төсвийн жилээр байгуулсан бол 113 байгууллагатай ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолоор

батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 2.6⁸-д заасны дагуу халаалтын улирал эхлэх буюу 09 дүгээр сарын 15-ны өдрөөс халаалтын улирал дуусах буюу дараа оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл байгуулсан байна.

1.2.5 Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 4.9-д “Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч, хэрэглэгч нь жил бүр тогтоосон халаалтын улирал дуусахад гэрээг дүгнэж, тооцоо нийлэн акт үйлдэж, халаалтын улирал эхлэх хугацаанд гэрээг шинэчлэн байгуулна.” гэж заасан боловч дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд болон дулаан хэрэглэгч төсвийн байгууллагууд нь гэрээний хэрэгжилтийг огт дүгнээгүй, тооцоо нийлж, акт үйлдээгүй байна.

1.2.6 Хангагч, хэрэглэгч нь халаалтын улирлын эцэст гэрээг дүгнэж, актаар баталгаажуулаагүй, гэрээг зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авч, хариуцлага тооцохгүй байгаа нь халаалт, дулааныг стандартын түвшинд өгөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.2.7 ЭХЗХ-ны 2019 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 6.2-т “Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын тухайн оны зорилтын биелэлтийг жил бүрийн 4 дүгээр сард багтаан ЭХЗХ-ны хурлаар хэлэлцэн дүгнэнэ.” гэж заасан байдаг.

1.2.8 Аймгийн ЭХЗЗ нь 2021 онд Ковид-19 цар тахлын улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон зорилтын биелэлтэд хяналт хийж, дүгнээгүй бол 2022 онд 15 аж ахуйн нэгжийг газар дээр нь шалгаж, хурлаар хэлэлцэж биелэлтийг үнэлж, дүгнэсэн байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхцөл, шаардлагын биелэлтийг үнэлсэн байдал

Хүснэгт №3

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Дулаанаар хангах сум, тосгоны нэр	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг үнэлж, дүгнэсэн	
			Үнэлгээ	Дүгнэсэн огноо, тогтоолын дугаар
1	“Мандал Энерго” ОНӨААТҮГ	Мандал	Хангалттай	2022.12.15 №35
2	“Спирт бал бурам” ХХК	Мандал	Хангалттай	2022.12.15 №31
3	“Эл Си Би” ХХК	Орхон, Цагааннуур, Шаамар сумын МСҮТ	Сайн	2022.12.15 №23
4	“Зоригт-Алтай” ХХК	Түшиг	Сайн	2022.12.15 №25
5	“Түнхэл дулаан” ХХК	Мандал сумын Түнхэл тосгон	Сайн	2022.12.15 №30
6	“Монжим трейд” ХХК	Жавхлант, Хушаат	Дунд	2022.12.15 №22
7	“Анужээ” ХХК	Баянгол	Дунд	2022.12.15 №24
8	“Хүдэр дулаан” ХХК	Хүдэр	Дунд	2022.12.15 №26
9	“Арвижих өргөө” ХХК	Мандал сумын Хэрх тосгон	Дунд	2022.12.15 №27
10	“Хэрх илч” ХХК		Дунд	2022.12.15 №28

⁸ Хангагч, хэрэглэгч нь дулаанаар хангах гэрээг жил бүрийн халаалтын улирал эхлэх хугацаанд буюу Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон хугацаанд байгуулж мөн тогтоосон халаалтын улирал дуусахад гэрээг дүгнэж, тооцоо нийлэн акт үйлдэнэ.

11	“Энержиплас инженеринг” ХХК	Баруунбүрэн, Сант	Дунд	2022.12.15 №29
12	“Гавшгай-Ус” ААТҮГ	Сайхан сумын Номгон тосгон	Дунд	2022.12.15 №33
13	УБТЗ.БАҮ-ний 1-р анги	Мандал	Дунд	2022.12.15 №34
14	“Туулын хишиг” ОНӨААТҮГ	Орхонтуул	Дунд	2022.12.15 №36
15	Алтанбилэг ХХК	Шаамар	Дунд	2022.12.15 №38


1.2.9 Дээрхээс үзэхэд Мандал сумын төсвийн байгууллагуудыг дулаанаар хангаж байгаа “Мандал Энерго” ОНӨААТҮГ, “Спирт бал бурам” ХХК-ийг **“Хангалттай”**, Орхон, Цагааннуур, Түшиг сумд, Мандал сумын Түнхэл тосгоны төсвийн байгууллагууд болон Шаамар сумын МСҮТ-ийг төвлөрсөн дулаанаар хангагч “Эл Си Би” ХХК, “Зоригт-Алтай” ХХК, “Түнхэл дулаан” ХХК -иудыг **“Сайн”** гэж үнэлсэн бол бусад 10 байгууллагыг **“Дунд”** гэж үнэлж, дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл хяналт шалгалт хэрэгжүүлсэн 15 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн дийлэнхийг буюу 66.7 хувийг **“Дунд”** гэж үнэлсэн нь халаалт дулаанаар хангах үйл ажиллагаа стандарт, шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.

1.2.10 ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 6.1-т **“Энэхүү дүрмийн биелэлтэд хангагч, хэрэглэгч талууд болон Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч хяналт тавина.”**, 2021 оны 499 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийн 2.1.2-т **“Олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан үйл ажиллагаа болон холбогдох дүрэм, журмын биелэлтэд хяналт тавих”** гэж заасны дагуу 2022 онд дараах хяналт, шалгалтыг хийсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах албан даалгавар болон ЭХЗЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч 16 аж ахуйн нэгжийн дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, ажлын байрны нөхцөл, шаардлагын биелэлтийг аймгийн ЗДТГ, МХГ-ын хамтарсан ажлын хэсэг газар дээр нь шалгаж, дүгнэлт гарган, зөвлөмж өгсөн байна.
- Дээрх хяналт, шалгалтын ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сард “Гавшгай-Ус” ААТҮГ, “Туулын хишиг” ОНӨААТҮГ, “Ануужээ” ХХК, “Монжим трейд” ХХК “Энержиплас инженеринг” ХХК-иудад илэрсэн зөрчилд Эрчим хүчний улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснийг дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах байгууллагууд хангаж ажилласан байна.


1.2.11 Аудитын явцад бид **“Google form”** хэрэглээний платформ ашиглан нийт 318 хэрэглэгчээс асуулга авч, нэгтгэн дүгнэлээ.

Дүрслэл №1



2021, 2022 онд танай байгууллагын өрөө тасалгааны халаалт аль түвшинд байна бэ? гэсэн асуултад 318 дулаан хэрэглэгчийн 36 нь маш сайн, 111 нь сайн, 115 нь дунд, 56 нь маш муу гэсэн хариултыг өгсөн буюу 54 хувь нь “Хангалтгүй” гэж хариулсан байна.

Дүрслэл №2



Халаалтын үйл ажиллагаатай холбоотойгоор гаргасан санал, гомдлыг дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд хэрхэн шийдвэрлэдэг бэ? гэсэн асуултад 314 дулаан хэрэглэгчийн 155 нь шуурхай шийдвэрлэдэг, 107 нь удаан хугацаанд шийдвэрлэдэг, 40 нь бараг шийдвэрлэдэггүй, 12 нь огт шийдвэрлэдэггүй гэсэн хариултыг өгсөн буюу 50.6 хувь нь удаан хугацаанд, бараг шийдвэрлэдэггүй, огт шийдвэрлэдэггүй гэж дүгнэсэн байна.

1.2.12 Өөрөөр хэлбэл дулаанаар хангагч байгууллагуудын халаалтын үйл ажиллагаа нь доголдолтой, хэрэглэгчдээс гаргасан санал гомдлыг шуурхай шийдвэрлэдэггүй зэрэг нь нөхцөл, шаардлагад нийцсэн дулаанаар хангаж чадахгүй, дулаан хэрэглэгчдийг хүйтний улиралд тав тухтай байх нөхцөлийг бүрдүүлэхгүй байгааг харуулж байна.

Бүлэг 2

Төсвийн байгууллагууд түлш халаалтын зардлыг бодитоор төлөвлөж, үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

Төсвийн байгууллагууд гэрээний хэрэгжилтийг дүгнэлгүйгээр халаалт дулааны төлбөрийг бүрэн төлсөн нь төсвийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.1 Түлш халаалтын зардлыг бодитоор төлөвлөж байна уу?

Төсвийн байгууллагууд нь шинэчилсэн тарифыг мөрдөж түлш, халаалтын зардлыг төлөвлөөгүйгээс батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.1.1 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын төсвийн 34, орон нутгийн төсвийн 159 зэрэг нийт 193 байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8.4.1⁹ дэх заалтын дагуу төсвийн төслийг боловсруулж, түлш халаалтын зардлыг 2021 онд 12,180.7 сая төгрөгөөр, 2022 онд 13,456.9 сая төгрөгөөр тус тус төсөвлөснийг 2021 онд 10,379.5, 2022 онд 13,579.9 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн байгууллагуудын түлш, халаалтын зардлын төсвийн төсөл

Хүснэгт №4

(сая төгрөг)

№	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Төсвийн төсөл		Батлагдсан төсөв	
			2021 он	2022 он	2021 он	2022 он
1	Улсын төсвийн байгууллага	34	2,801.9	2,784.9	1,634.3	2,232.7
2	Орон нутгийн төсвийн байгууллага	159	9,378.8	10,672.0	8,745.2	11,347.2
Нийт		193	12,180.7	13,456.9	10,379.5	13,579.9

2.1.2 ЭХЗХ-ны 2019 оны 457, 458, аймгийн ЭХЗЗ-ийн 2016 оны 07-26 дугаар тогтоолуудаар баталсан үнэ тарифыг ихэнх төсвийн байгууллагууд 2022 он хүртэл мөрдөлгүйгээр, түлш халаалтын зардлыг хуучин тарифаар тооцон төлөвлөж байсан байна.

2.1.3 Шинэчлэн баталсан дээрх үнэ тарифыг ихэнх байгууллагууд мөрдөөгүйгээс түлш халаалтын зардлын төсвийг 2021 онд 511.7 сая төгрөгөөр, 2022 онд 149.7 сая төгрөгөөр тус тус дутуу тооцон төлөвлөж, батлуулсан байна.

Тогтоосон тарифаас зөрүүтэй тооцсон байдал

Хүснэгт №5

(сая төгрөг)

Тайлант он	Батлагдсан тарифаар тооцсон дүн	Батлагдсан төсөв	Зөрүү
			Нийт
2021	10,152.6	9,640.9	(511.7)
2022	12,824.9	12,675.2	(149.7)

2.1.4 Аймгийн ЭХЗЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 05-20 дугаар тогтоолуудаар дулааны үнэ тарифыг 20.0-30.0 хувиар нэмэгдүүлж, 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж эхлэхээр тогтоосон нь Төсвийн тухай хуулийн 6.2.5-д “Төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” гэж заасныг зөрчсөн байна.

⁹ Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 09-ний дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх

2.1.5 Дээрх тогтоолоор тогтоосон үнэ тарифыг үндэслэн нэг талаас дулаанаар хангагч байгууллага төлбөрийн нэхэмжлэл хүргүүлж, авлага үүсгэн тайлагнасан бол нөгөө талаас төсвийн байгууллагууд нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөлгүйгээр санхүүгийн тайланд өр төлбөр тайлагнаагүйгээс харилцагч талуудын хооронд ихээхэн хэмжээний төлбөрийн зөрүү үүссэн байна.

2.1.6 Аймгийн ТЭЗ-ийн харьяа 159 байгууллагын түлш халаалтын зардлын батлагдсан төсвийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 2021 онд 1,520.8 сая төгрөгөөр, 2022 онд 2,936.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Түлш, халаалтын зардлын өмнөх оны гүйцэтгэл
болон тухайн оны батлагдсан төсвийн зөрүү**

Хүснэгт №6

(сая төгрөг)

Тайлант он	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Зөрүү	
			Дүн	Нэмэгдсэн хувь
2021	7,082.6	8,745.2	1,662.6	23.5
2022	7,889.3	11,347.2	3,457.9	43.8


2.1.7 Төсвийн байгууллагуудын түлш, халаалтын зардлын батлагдсан төсөв нь өмнөх оны гүйцэтгэлээс 23.5-43.8 хувиар өссөн нь Эрчим хүчний сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 170 дугаар тушаалаар Сэлэнгэ аймагт түлш, халаалтын зардлыг 8 сараар тооцох болсноос болон үнэ тарифын өсөлтийг мөрдөж эхэлснээс голлон шалтгаалсан байна.

2.1.8 Орон нутгийн төсвөөс санхүүжих 159 байгууллагын түлш, халаалтын зардлыг аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор 8,745.2 сая төгрөгөөр, 2022 оны 55 дугаар тогтоолоор 11,347.2 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

**Орон нутгийн төсвийн байгууллагуудын түлш, халаалтын
зардлын төлөвлөлт**

Дүрслэл №3

(сая төгрөг)



2.1.9 Орон нутгийн төсөвт байгууллагууд нь түлш, халаалтын зардлыг өмнөх оны гүйцэтгэл, дулаанаар хангагч байгууллагуудтай хийсэн гэрээ, мөрдөж байгаа үнэ тарифыг үндэслэж бодитоор төлөвлөдөггүйгээс төсвийн жилийн дундуур тодотгол хийж, түлш халаалтын зардалд өөрчлөлт оруулсан байна.

2.2 Түлш халаалтын зардлыг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

Аймгийн ЭХЗЗ төсвийн жилийн дундуур дулааны тарифыг шинэчлэн, мөрдөх шийдвэр гаргасан нь төсвийн байгууллагуудад түлш, халаалтын өр төлбөр үүсэх эрсдэлийг дагуулж байна.

2.2.1 Аудитад хамрагдсан төсвийн 193 (Төвлөрсөн халаалттай 169, өөрийн галлагаатай 21, цахилгаанаар халаадаг 3) байгууллага нь түлш, халаалтын зардалд 2021 онд 10,379.5 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 9,947.0 сая төгрөг, 2022 онд 13,579.7 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 12,852.9 сая төгрөг тус тус зарцуулж, батлагдсан төсвийг 2021 онд 432.5 сая төгрөгөөр, 2022 онд 727.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсвийн байгууллагуудын түлш, халаалтын зардлын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлт

Хүснэгт №7

(сая төгрөг)

№	Байгууллагын төрөл	Халаалтын төрөл	2021 он			2022 он		
			Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэсэн/Хэтэрсэн	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэсэн/Хэтэрсэн
1	Улсын төсвийн байгууллага	Төвлөрсөн	1,387.7	1,279.6	108.1	1,925.1	1,633.9	291.2
		Өөрийн галлагаатай	192.5	193.8	(1.3)	264.5	268.0	(3.5)
		Цахилгаан	54.1	54.1	-	43.1	39.2	3.9
2	Орон нутгийн төсвийн байгууллага	Төвлөрсөн	8,253.2	7,942.3	310.9	10,750.0	10,354.3	395.7
		Өөрийн галлагаатай	391.9	407.7	(15.8)	516.6	473.4	43.2
		Цахилгаан	100.1	69.5	30.6	80.6	84.1	(3.5)
Нийт дүн			10,379.5	9,947.0	432.5	13,579.9	12,852.9	727.0

Эх сурвалж:Түлш халаалтын зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа

2.2.2 Түлш, халаалтын зардлын батлагдсан төсвийг төвлөрсөн халаалттай байгууллагууд 2021 онд 419.0 сая төгрөгөөр, 2022 онд 686.9 сая төгрөгөөр, цахилгаанаар халаадаг байгууллагууд 2021 онд 30.6 сая төгрөгөөр, 2022 онд 0.4 сая төгрөгөөр, өөрийн галлагаатай байгууллагууд 2022 онд 39.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

2.2.3 Дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд болон дулаан хэрэглэгч төсвийн байгууллагууд нь гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж, дулааны төлбөр тооцоог гүйцэтгэхгүй байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчдийг гэрээнд заасан стандартын шаардлага, тасалгааны температурт нийцсэн дулаанаар хангаагүй тохиолдолд ч төсвийн байгууллагууд төлбөр тооцоог бүрэн шилжүүлж байна.

2.2.4 Дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд болон дулаан хэрэглэгч төсвийн байгууллагуудын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж, түүнд үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэснээр түлш халаалтын зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талтай юм.

2.2.5 Тухайлбал аудитын явцад төсвийн байгууллагуудаас авсан “Танай байгууллагын өрөө тасалгааны халаалт аль түвшинд байна вэ” гэсэн асуултад албан тушаалтнуудын 17.6 хувь нь “Маш муу” гэж хариулсан бөгөөд үүнээс

үндэслэн халаалтын түвшинтэй уялдуулан тухайн жилийн түлш халаалтын төлбөрийг 10 хувь дутуу шилжүүлэхэд жилд дунджаар 1,285.3 сая төгрөг хэмнэх боломжтой байна.

2.2.6 Төсвийн байгууллагууд нь аймгийн ЭХЗЗ-өөс шинэчлэн баталсан дулааны үнэ тарифыг мөрдөөгүй, санхүүгийн тайлан балансанд өр төлбөрийг тусгаагүй байна. Энэ нь халаалт дулаанаар хангагч аж ахуйн нэгжүүд хууль, шүүхийн байгууллагад хандаж, үнийн зөрүүгээс үүссэн төлбөрийг нэхэмжлэх, алданги тооцох, төлөвлөөгүй төсвийн зарлагыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

2.2.7 Тухайлбал, Сайхан сумын төсвийн байгууллагуудыг дулаанаар хангагч “Хөтөл энерги дулаан” ХХК нь 2022 онд хууль хяналтын байгууллагад хандаж түлш, халаалтын авлагыг нэхэмжилснээр шүүхийн шийдвэр гарч дараах байгууллагууд түлш, халаалтын өр төлбөрийг төлж, барагдуулсан байна. Үүнд:

- Сайхан сум дахь Сум дундын Шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 152 захирамжийн дагуу тус сумын Соёлын ордон 2022 оны 9-12 дугаар сард 11.4 сая төгрөгийн өрийг барагдуулсан,
- Сайхан сум дахь Сум дундын Шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 160 дугаар захирамжийн дагуу тус сумын 2 дугаар цэцэрлэг 2022 оны 9-12 дугаар сард 23.8 сая төгрөгийг өрийг барагдуулсан байна.

2.2.8 Аудитад хамрагдсан 2021-2022 онуудад өөрийн галлагаатай улсын төсвийн 2, орон нутгийн төсвийн 4 байгууллага нь түлш халаалтын зардлын батлагдсан төсвийн хүрээнд хууль, журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, нүүрс худалдан авсан байна. Үүнд:

- 2021 онд түлш халаалтын зардалд 65.8-75.7 сая төгрөгийн, 2022 онд 74.6-111.6 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ШШГЕГ-ын 413 дугаар хорих анги, ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих анги, Мандал сумын 1 дүгээр сургууль зэрэг 4 байгууллага цахим нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж, нүүрс худалдан авсан,
- Түлш халаалтын зардалд 2021 онд 39.8 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй Сүхбаатар сумын 6 дугаар сургууль, 2022 онд 47.9-65.0 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй Сүхбаатар сумын 6 дугаар сургууль, Мандал сумын 1 дүгээр сургууль нь харьцуулалтын аргаар нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, нүүрс, түлээний мод худалдан авсан байна.

2.2.9 Өөрийн галлагаатай байгууллагуудын түлш халаалтын зардалд 2021 онд 5.2-9.2 сая төгрөг батлагдсан улсын төсвийн 1, орон нутгийн төсвийн 4, 2022 онд 6.7-13.2 сая төгрөгийн төсөв батлагдсан улсын төсвийн 1, орон нутгийн төсвийн 5 байгууллага шууд гэрээ байгуулан нүүрс, түлээ худалдаж авсан байна.

2.2.10 Орон нутгийн төсвийн зарим байгууллагууд (2021 онд 8, 2022 онд 6) нь шууд худалдан авалтын босго үнээс давсан нүүрс, түлээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар бус шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 6.1¹⁰, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ТБОНӨХБАУХА ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийг 2¹¹, 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан ТБОНӨХБАУХА

¹⁰ Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹¹ Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа 10.0 сая төгрөг, Ажил 10.0 сая төгрөг.

ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн 2¹² дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Харьцуулалтын аргын босго үнээс давсан нүүрс, түлээний модны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байгууллагууд

Хүснэгт №9

(сая төгрөг)

№	Байгууллагын төрөл	Төсвийн байгууллагын нэр	Түш, халаалтын зардлын батлагдсан төсөв	
			2021 он	2022 он
1	Орон нутгийн төсвөөс санхүүжих байгууллага	Сүхбаатар сумын 5 дугаар сургууль	43.8	42.2
2		Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг	26.9	30.3
3		Шаамар сумын Дулаанхаан тосгоны Эрүүл мэндийн төв	19.6	46.5
4		Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба	15.3	-
5		Орхонтуул сумын Рашаант тосгоны Соёлын төв	15.0	-
6		Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэндийн төв	14.4	37.1
7		Мандал сумын 3 дугаар цэцэрлэг / 2 дугаар байр /	12.0	23.3
8		Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг	11.1	-
9		Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг	-	23.9
Нийт дүн			158.1	203.3

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **661.4** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ болон “Илдэн бүрэн” ААТҮГ нь тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж байна.
- Төсвийн байгууллагууд шинэчилсэн тарифыг мөрдөөгүйгээс түлш халаалтын зардлын төсвийг 2021 онд 511.7 сая төгрөгөөр, 2022 онд 149.7 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөж, батлуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрөлгүй орон нутгийн өмчит газрууд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа явуулж байгаа нь төсвийн байгууллагуудыг стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

¹² Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа 20.0 сая төгрөг, Ажил 20.0 сая төгрөг.

- Төсвийн байгууллагууд нь дулаанаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүйгээс түлш, халаалтын зардлыг хэмнэх боломжийг алдсан байна.
- Төсвийн байгууллагууд нь шинэчилсэн тарифыг мөрдөж түлш, халаалтын зардлыг төлөвлөөгүйгээс батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.
- Аймгийн ЭХЗЗ төсвийн жилийн дундуур дулааны тарифыг шинэчлэн, мөрдөх шийдвэр гаргасан нь төсвийн байгууллагуудад түлш, халаалтын өр төлбөр үүсэх эрсдэлийг дагуулж байна.
- Төсвийн байгууллагууд гэрээний хэрэгжилтийг дүгнэлгүйгээр халаалт дулааны төлбөрийг бүрэн төлсөн нь төсвийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ЭХЗЗ-ийн дарга Ж.Сайнцог-д

- Эрчим хүчний тухай хуульд заасан эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа, үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл болон байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг баримт материалыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгож байх.
- Төсвийн жилийн дундуур төсвийн зарлага буюу түлш, халаалтын зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болох дулааны тарифыг нэмэгдүүлж, мөрдөх шийдвэр гаргахгүй байх.
- Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох стандарт, журмын дагуу хөтөлж, архивын нэгж үүсгэх.

Сумдын Засаг дарга нарт:

- Төсвийн байгууллагуудыг дулаанаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагыг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах.
- Дулаанаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, төсвийн байгууллагуудыг хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангах.

Төсвийн байгууллагын дарга, удирдлагуудад:

- Түлш, халаалтын зардлын төсвийг өмнөх оны гүйцэтгэл, дулаан хангагч аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээ болон мөрдөж буй үнэ тарифыг үндэслэн төлөвлөж, батлуулах.
- Дулаанаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэсний үндсэн дээр түлш, халаалтын зардлыг төлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах.

- Түлш, халаалтын зардлын авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж, тайлагнах.
- Нүүрс, түлээний модны худалдан авалтыг хууль, журмын дагуу зохион байгуулж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БААСАНСҮРЭН

АУДИТОР

О.АНХБАЯР

Б.НАРАНЦЭЦЭГ

Т.МӨНХЗУЛ

АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС ИРҮҮЛСЭН САНАЛ



МОНГОЛ УЛС
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛ

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум,
Утас/Факс: 7036-2266

2023.11.20 № 44
танай 2023.11.20 -ны № 135

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА
ТАНАА

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд
танай байгууллагаас ирүүлсэн 2023 оны 135 тоот
албан бичигтэй танилцан доорх хариуг хүргүүлж
байна.

“Төсвийн байгууллагуудын халаалтын зардлын
төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцан манай байгууллагаас
тус төсөлтэй холбогдон гаргах санал байхгүй болно.

ДАРГА



Ж.САЙНЦОГ

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

